



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хархорин АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2022/2/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр хот 2022 он	Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: gansukhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК” Утас: 70005711 Цахим хаяг: dulguunkhairkhanuulaudit09@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ /Баталгаажсан хувийг оруулах/

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хархорин АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хархорин АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/мянган төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	539,031.3	625,194.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,218,384.6	1,187,789.0
	Нийт хөрөнгийн дүн	1,757,415.9	1,812,983.8
	Нийт өр төлбөрийн дүн	276,466.6	283,062.9
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,480,949.3	1,529,920.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,757,415.9	1,812,983.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,107,617.9	2,453,414.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,058,178.5	2,406,976.1
	Үйл ажиллагааны үр дүн	49,439.4	46,468.0
	Үйл ажиллагааны бус үр дүн	-4,943.9	-4,646.8
	Үйл ажиллагааны нийт үр дүн	44,495.4	41,821.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,436,453.8	1,488,099.7
	Тайлант оны үр дүн	44,495.4	41,821.2
	Эцсийн үлдэгдэл	1,480,949.2	1,529,920.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,395,014.6	2,819,015.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,382,683.7	2,587,393.7
	Үйл ажиллагааны ЦМГ	12,330.9	231,621.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	12,330.9	231,621.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	184,762.2	197,093.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	197,093.1	428,715.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	-
	Урсгал зардал	-	-
	Нийт зардал	2,058,178.5	2,406,976.1
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	-
	Нийт орлого	2,107,617.9	2,453,414.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу компанийн үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Компанийн эрхэм зорилго:

Хархорин АЗЗА ТӨХК-ийн зорилго нь Төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг шуурхай зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгаж ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл:

Хархорин АЗЗА ТӨХК нь улсын чанартай авто замын засвар арчлалт, шугамын хэсгүүдийг шуурхай удирдлагаар хангаж хариуцсан замын байгууламжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх нөхцөл бүрдүүлэх,

Замын барилгын үйлдвэрлэл эрхэлж тоног төхөөрөмж, машин механизмыг үр ашигтай ажиллуулах түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх гэж тодорхойлжээ

Гурав. Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсноор аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байна. Засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаанаас аудитын гол асуудлыг сонгоно.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзнэ.

Дээрх асуудлын талаар олон нийтэд ил тод мэдээлэхийг хууль тогтоомжоор хориглосон, уг мэдээллийг ил тод болгосноор нийгэмд учрах сөрөг үр дагавар нь олон нийтийн хүртэх үр өгөөжөөс давамгайл гэж үзэх үндэслэлтэй байхаас бусад тохиолдолд аудитор аудитын гол асуудал бүрийг аудитын тайланд оруулна.

Тус стандартад зааснаар тухайн асуудлын үр дүнгээс болоод аудитор дүгнэлтээ өөрчлөхөд хүрсэн бол тэрээр аудитын гол асуудал хэсэгт тодорхойлсон асуудлыг мэдээлэхгүй байх нь зүйтэй.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал нь худалдан авах ажиллагаа болон гэрээний гүйцэтгэл шалгах.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 144,722.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 144,722.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 144,722.2 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 9,627.8 мянган төгрөгийн материаллагын түвшинээс их байгаа ч материаллаг бус гэж үзэн Зөрчилгүй дүгнэлт өглөө.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тодруулга-Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2021 оны 3 сарын худалдан авалтын 2,603.6 мянган төгрөгийн зарлагын баримтыг тайланд тусгаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайлан санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд бүрэн тусгах.

2. Тодруулга-Засгийн газрын хувь оролцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээлэлд 1 тайлан огт оруулаагүй ба энэ нь санхүүгийн тайлангийн аудит дуусгавар болоогүй байгаатай холбоотой. Тайлан төсөв гүйцэтгэлийн мэдээнээс хоцорсон 3 тайлан, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтаас хоцорсон 2 тайлан, бусад мэдээнээс 3 хоцорсон тайлан буюу нийтдээ 1 тайлан оруулаагүй, 8 хоцорсон тайлан байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн дагуу цаг хугацаанд нь заавар журмын дагуу мэдээллүүдээ мэдээлж байх.

3. Тодруулга-Засгийн газрын хувь оролцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт:

2019 оны 10 сарын 19-нд дүрмийн сан өөрчилсөн бүртгэл хийлгэж 601,647.37 мянган төгрөг болсон ч 2021 оны тайлангаар 743,765.95 мянган төгрөг байна. Тус дүрмийн сангийн өөрчлөлтийг одоог хүртэл Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт хийгдээгүй явж байна.

Өгсөн зөвлөмж:

Компанийн тухай хуулийг дагаж мөрдөх, Улсын бүртгэлд бүртгэлээ цаг тухайд оруулж байх, Дүрмийн санд өөрчлөлт орох бүрд өөрчлөлтийг хийлгэх.

4. Тодруулга-Биет бус хөрөнгө холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага “MACS” програм ашигладаг боловч ажилчидын цалин, амралт зэрэг бүртгэлийг EXCEL програмаар хөтлөж байгаа нь хангалтгүй, мэдээлэл хэрэглэгчдийн шаардлагад нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 47 тоот тушаал "Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн програмд тавигдах шаардлага"-ыг мөрдөж ажиллах, програмаа сайжруулах.

5.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС /ТБОНӨҮГ/	1	1			1			
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

5.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Төсөл, хөтөлбөр										
2	ЗГТС /ТБОНӨҮГ/	4	144.7							4	144.7
3	ТТЗ										
4	ТЕЗ										
	Дүн	4	144.7							4	144.7
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Төсөл, хөтөлбөр										
2	ЗГТС /ТБОНӨҮГ/										
3	ТТЗ										
4	ТЕЗ										
	Дүн										
	НИЙТ ДҮН	4	144.7							4	144.7